



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 05 дугаар сарын 28 өдөр Дугаар 37

Хэрлэн сум

XXXVII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 37 дугаар хурал 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 94,2 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. "COVID-19" өвчний цаг үеийн мэдээлэл танилцуулах:

*Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн
хэлтсийн дарга Ч
.Оюунтунгалаг*

2. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-аас аймгийн Онцгой комиссын дарга, Засаг даргад ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэх:

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

3. Хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цагийг өнгөрөөх талбайг нээх эсэх талаар:

*Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа,
Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан*

4. Хэрлэн суманд зохион байгуулсан "Зад цэвэрлэе" хог цэвэрлэгээний ажлын талаарх мэдээлэл танилцуулах:

Хэрлэн сумын Засаг даргын орлогч О.Пүрэв-Очир

5. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгаас Дорнод аймагт үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах ажлын хэсгийг томилгоожуулах талаар:

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

6. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх талаар:

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан

7.Бүсийн оношлогоо эмчилгээний төвд зөөврийн гэрэл худалдан авах хөрөнгийг хэлэлцэж шийдвэрлүүлэх:

Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал Д.Должин

8.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалтыг танилцуулах:

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

9."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн газрын тос тээвэрлэх автомашиныг нэмэгдүүлэх хүсэлтийг танилцуулах:

Автотээврийн төвийн дарга Ц.Мөнхтөр

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,

Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

1.1.Улсын Онцгой комиссын 22 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасантай холбогдуулан аймгийн Засаг даргаас гарсан шийдвэрүүдийг сунгаж баталгаажуулахыг,

Хоёр. Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч

дарга Ч.Ганбат-д:

2.1."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-аас аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн хүсэлтийг Улсын Онцгой комисс, Монгол Улсын Шадар сайдад аймгийн Засаг даргын албан бичгээр уламжлахыг,

Гурав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтүяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа нарт:

3.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн тоглоомын талбайг нээхтэй холбогдуулан эрүүл ахуй, халдваргүйжүүлэлт болон нэг дор 10-аас олон хүүхэд цуглуулахгүй байхад эргүүл, жижүүрүүд хяналт тавьж ажиллах тухай зөвлөмжийг гаргаж хэрэгжилтийг зохион байгуулахыг,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын

дарга Э.Жавхлан-д:

3.2.Аймгийн Онцгой комиссын 38 дугаар хуралдаанд хүүхдийн тоглоомын талбайг нээх эсэх талаар санал боловсруулж танилцуулахыг,

Дөрөв. АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,

Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтүяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа нарт:

4.1.БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгаас Дорнод аймагт үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах ажлын хэсгийг АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Алтансүхээр ахлуулж Мэргэжлийн

хяналтын газар, Эрүүл мэндийн газрын холбогдох гишүүдийн бүрэлдэхүүнтэй байхаар шийдвэрлэв,

Тав.Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

5.1. 2020 оны 05 дугаар сарын 03-ны өдөр "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн газрын тос тээвэрлэлтийн туслан гүйцэтгэгч компанийн жолооч иргэн Б-д коронавируст халдварын сэжигтэй тохиолдол илэрч БОЭТ-ийн Халдвартын тасагт тээвэрлэхэд гарсан шатахууны зардал 200,000 төгрөгийг тухайн аж ахуй нэгж байгууллагаас гаргуулахыг,

Зургаа.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

6.1.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиож байгаатай холбогдуулан үйлчилгээний байгууллагуудын хяналт шалгалтыг эрчимжүүлэх, зөвлөмж хүргүүлж ажиллахыг,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан-д:

6.2.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн баярын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахыг,

6.3.Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлаар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн баярын үйл ажиллагааг зохион байгуулах тухай саналыг танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Долоо.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:


7.1.Эмнэлгийн зориулалттай зөөврийн гэрэл худалдан авах зардалд 2,380,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн оношлогоо эмчилгээний төвд олгохыг,

Найм.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

8.1."Петрочайна Дачин Тамсаг" компанийн газрын тос тээвэрлэх автомашиныг нэмэгдүүлэх хүсэлтийг мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн газрын тос тээвэрлэлтийн автомашиныг нэмэгдүүлэх боломжгүй болохыг аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА